



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/136/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор П.Цэцэгдулам
Утас: 7033-3019

Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 96
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БОЛОРМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрийн 66,682.6 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг байгууллагын зардлаас олгосон;
2. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс бэлэг дурсгал, онгоцны тийзний зардалд нийт 184,733.5 мянган төгрөгийг хэмнэлтгүй зарцуулсан;
3. Байгууллагын өмч хөрөнгөд бүртгэлтэй 235,958.7 мянган төгрөгийн хөрөнгийг эд хариуцагчийн картаар бүртгэлжүүлээгүй, эзэмшигч нь тодорхойгүй байхад жилийн эцсийн тооллогын комисс, өмч хамгаалах байнгын зөвлөлөөс холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй;

Дээрх зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6, 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3, 15.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”- 2.2.2, 3.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 6,626,655.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 5,777,795.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 67 үндсэн зорилтын хүрээнд 150 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
35	БАРАА МАТЕРИАЛ	85,702,848.00	78,828,308.00
354	Хангамжийн материал	85,702,848.00	78,828,308.00
3541	Бичиг хэргийн материал	27,404,100.00	26,296,600.00
3542	Аж ахуйн материал	35,289,398.00	35,274,008.00
3543	Сэлбэг хэрэгсэл	2,747,200.00	2,747,200.00
3544	Түлш, шатах тослох материал	5,751,650.00	
3545	Барилгын засварын материал	45,000.00	45,000.00
3547	Бусад хангамжийн материал	14,465,500.00	14,465,500.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	85,702,848.00	78,828,308.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,535,897,243.25	5,795,321,255.12
392	Биет хөрөнгө	4,038,147,243.25	4,925,138,255.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,549,582,537.50	3,683,962,092.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-301,475,221.57	-363,177,226.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	343,550,000.00	893,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-267,694,999.99	-316,994,999.97
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	691,066,587.30	1,065,265,407.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-232,249,421.69	-350,320,318.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	369,716,878.00	466,457,814.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	-163,705,643.87	-192,537,290.79
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	37,250,000.00	37,250,000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-12,943,472.38	-16,333,888.89
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,700,000.00	34,700,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,650,000.05	-16,983,333.31
393	Биет бус хөрөнгө	497,750,000.00	870,183,000.00
39301	Програм хангамж	900,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-900,000.00	-900,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	497,750,000.00	870,959,434.81
39304	Хуримтлагдсан элэгдэл		-776,434.81
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,535,897,243.25	5,795,321,255.12
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,621,600,091.25	5,874,149,563.12
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		23,611,930.00
413	Өглөг		23,611,930.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		5,515,500.00
4136	Бусад өглөг		18,096,430.00
41361	Байгууллагад төлөх өглөг		18,096,430.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		23,611,930.00
51	Засгийн газрын хувь оролцоо	4,621,600,091.25	5,850,537,633.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,223,981,214.28	2,223,981,214.28
51101	Өмч: - төрийн	2,223,981,214.28	2,223,981,214.28

512	Хуримтлагдсан үр дүн	124,009,378.24	1,352,946,920.11
5121	Өмнөх үеийн үр дүн	124,009,378.24	124,009,378.24
5122	Тайлант үеийн үр дүн		1,228,937,541.87
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,273,609,498.73	2,273,609,498.73
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,621,600,091.25	5,850,537,633.12
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,621,600,091.25	5,874,149,563.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,056,470,258.00	7,124,308,705.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,297,602,958.00	503,421,605.13
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	69,287,400.00	55,016,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	258,738,150.00	340,197,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	969,577,408.00	108,207,355.13
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,758,867,300.00	6,620,887,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,758,867,300.00	6,620,887,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	990,047,225.93	996,529,592.51
120	Нийтлэг татварын бус орлого	990,047,225.93	996,529,592.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,475,100.00	5,768,000.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,475,100.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	980,247,335.93	990,184,820.43
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	324,790.00	576,772.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,046,517,483.93	8,120,838,297.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,052,899,448.08	6,891,900,755.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,497,334,838.10	5,786,589,766.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,463,385,028.98	2,765,701,582.58
210101	Үндсэн цалин	1,350,206,795.00	1,385,155,376.65
210102	Нэмэгдэл	851,294,551.98	950,673,791.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,200,375.00	191,135,790.43
210104	Урамшуулал	132,537,807.00	181,662,708.00
210105	Гэрээт ажлын хөлс	32,145,500.00	57,073,916.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	292,070,310.49	340,431,416.37
210201	Тэтгэврийн даатгал	198,756,006.00	237,266,723.88
210202	Тэтгэмжийн даатгал	23,114,905.60	25,706,972.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,369,352.69	12,687,166.98
210204	Ажилгүйдлийн даатгал	10,204,340.67	12,273,195.79
210205	Эрүүл мэндийн даатгал	48,625,705.53	52,497,357.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	263,827,078.60	276,583,560.58
210301	Гэрэл, цахилгаан	12,689,034.00	20,208,153.00
210302	Түлш, халаалт	241,683,216.00	242,252,516.00
210303	Цэвэр, бохир ус	9,454,828.60	14,122,891.58
2104	Хангамж, бараа материалын зардал	232,730,112.95	180,355,716.00
210401	Бичиг хэрэг	49,835,640.00	27,413,842.00
210402	Тээвэр, шатахуун	82,662,160.00	86,889,034.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,915,927.95	21,315,560.00
210404	Ном, хэвлэл	25,800,000.00	450,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,225,000.00	630,000.00

Архангай аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,149,885.00	38,764,080.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	26,141,500.00	4,893,200.00
2105	Нормативт зардал	8,108,000.00	
210502	Хоол, хүнс	1,960,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,148,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,581,150.00	27,570,560.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,511,000.00	
210602	Тавилга		600,000.00
210604	Урсгал засвар	71,070,150.00	26,970,560.00
2107	Томилолт, зочны зардал	134,861,200.00	149,043,800.00
210702	Дотоод албан томилолт	134,861,200.00	149,043,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,551,880.00	20,028,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,615,000.00	13,221,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,471,500.00	
210803	Даатгалын үйлчилгээ		2,444,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	388,620.00	439,304.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,472,200.00	3,735,900.00
210807	Газрын төлбөр	3,527,560.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,995,220,077.08	2,026,874,676.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,729,140,728.00	1,741,750,323.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	157,380,449.00	35,849,825.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,698,900.08	249,274,528.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	555,564,609.98	1,105,310,989.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		1,423,616.80
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		1,423,616.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	311,971,152.00	252,016,129.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,717,300.00	167,656,192.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	186,491,540.00	12,294,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	105,762,312.00	72,065,937.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	243,593,457.98	851,871,243.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	218,736,836.48	848,859,669.28
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	24,856,621.50	3,011,574.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,052,899,448.08	6,891,900,755.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	993,618,035.85	1,228,937,541.87
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	511,583.28	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	511,583.28	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-511,583.28	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	993,106,452.57	1,228,937,541.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,065,945,358.00	7,130,076,705.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,475,100.00	5,768,000.08
120	Нийтлэг татварын бус орлого	9,475,100.00	5,768,000.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,475,100.00	5,768,000.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,475,100.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,056,470,258.00	7,124,308,705.13
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,297,602,958.00	503,421,605.13
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	69,287,400.00	55,016,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	258,738,150.00	340,197,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	969,577,408.00	108,207,355.13
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,758,867,300.00	6,620,887,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,758,867,300.00	6,620,887,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,924,829,358.00	6,611,562,985.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,924,829,358.00	6,611,562,985.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,374,332,958.02	5,504,473,012.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,459,711,988.98	2,765,701,582.58
210101	Үндсэн цалин	1,346,999,789.00	1,391,081,374.65
210102	Нэмэгдэл	850,930,059.98	950,673,719.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,098,833.00	191,135,790.43
210104	Урамшуулал	132,537,807.00	181,662,780.00
210105	Гэрээт ажлын хөлс	32,145,500.00	51,147,918.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	292,070,310.49	340,431,416.37
210201	Тэтгэврийн даатгал	199,140,566.00	237,266,723.88
210202	Тэтгэмжийн даатгал	23,018,765.60	25,706,972.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,165,354.31	12,687,166.98
210204	Ажилгүйдлийн даатгал	10,198,739.88	12,273,195.79
210205	Эрүүл мэндийн даатгал	47,546,884.70	52,497,357.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	263,827,078.60	279,328,595.38
210301	Гэрэл, цахилгаан	12,689,034.00	21,529,571.00
210302	Түлш, халаалт	241,683,216.00	242,252,516.00
210303	Цэвэр, бохир ус	9,454,828.60	15,546,508.38
2104	Хангамж, бараа материалын зардал	201,956,912.95	126,695,100.00
210401	Бичиг хэрэг	23,600,800.00	15,015,100.00
210402	Тээвэр, шатахуун	80,334,900.00	60,331,740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,915,927.95	21,084,960.00
210404	Ном, хэвлэл	52,500,000.00	450,000.00

Архангай аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,225,000.00	630,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,380,285.00	29,183,300.00
2105	Нормативт зардал	4,706,000.00	
210502	Хоол, хүнс	1,960,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,746,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,116,450.00	24,874,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		540,350.00
210602	Тавилга		3,000,000.00
210604	Урсгал засвар	72,116,450.00	21,334,200.00
2107	Томилолт, зочны зардал	134,861,200.00	143,643,800.00
210702	Дотоод албан томиллолт	134,861,200.00	143,643,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,736,880.00	14,458,354.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,615,000.00	7,921,950.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,471,500.00	2,444,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	388,620.00	439,304.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	187,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,657,200.00	3,465,800.00
210807	Газрын төлбөр	3,527,560.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,912,346,137.00	1,809,339,614.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,752,965,488.00	1,775,726,189.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	159,380,649.00	33,613,425.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	550,496,399.98	1,107,089,972.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	306,902,942.00	255,218,729.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,717,300.00	167,656,192.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	186,491,540.00	12,294,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,694,102.00	75,268,537.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	243,593,457.98	851,871,243.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	218,736,836.48	848,859,669.28
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	24,856,621.50	3,011,574.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	141,116,000.00	518,513,720.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	141,116,000.00	518,513,720.00
	Дотоод эх үүсвэрээр	141,116,000.00	518,513,720.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	141,116,000.00	518,513,720.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-141,116,000.00	-518,513,720.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,223,981,214.28	2,273,609,498.73	-876,130,914.33	3,621,459,798.68
7	Тайлант үеийн үр дүн			993,106,452.57	993,106,452.57
10	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,223,981,214.28	2,273,609,498.73	124,009,378.24	4,621,600,091.25
17	Тайлант үеийн үр дүн			1,228,937,541.87	1,228,937,541.87
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,223,981,214.28	2,273,609,498.73	1,352,946,920.11	5,850,537,633.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРДЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,680,140,400.00	5,777,795,400.80	902,344,999.20	86.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,180,140,400.00	5,277,795,430.80	902,344,969.20	85.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,902,321,100.00	5,022,576,701.80	879,744,398.20	85.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,218,684,800.00	2,708,627,666.58	510,057,133.42	84.15
210101	Үндсэн цалин	1,343,139,500.00	1,385,155,376.65	-42,015,876.65	103.13
210102	Нэмэгдэл	1,550,553,100.00	950,673,719.50	599,879,380.50	61.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,677,600.00	191,135,790.43	-76,458,190.43	166.67
210104	Урамшуулал	210,314,600.00	181,662,780.00	28,651,820.00	86.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	418,558,400.00	333,327,146.84	85,231,253.16	79.64
210201	Тэтгэврийн даатгал	289,171,100.00	230,162,454.35	59,008,645.65	79.59
210202	Тэтгэмжийн даатгал	32,346,800.00	25,706,972.53	6,639,827.47	79.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,173,400.00	12,687,166.98	3,486,233.02	78.44
210204	Ажилгүйдлийн даатгал	16,173,400.00	12,273,195.79	3,900,204.21	75.89
210205	Эрүүл мэндийн даатгал	64,693,700.00	52,497,357.19	12,196,342.81	81.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	393,258,300.00	279,328,595.38	113,929,704.62	71.03
210301	Гэрэл, цахилгаан	22,712,000.00	21,529,571.00	1,182,429.00	94.79
210302	Түлш, халаалт	352,066,300.00	242,252,516.00	109,813,784.00	68.81
210303	Цэвэр, бохир ус	18,480,000.00	15,546,508.38	2,933,491.62	84.13
2104	Хангамж, бараа материалын зардал	142,984,600.00	126,252,300.00	16,732,300.00	88.3
210401	Бичиг хэрэг	19,896,000.00	15,015,100.00	4,880,900.00	75.47
210402	Тээвэр, шатахуун	62,073,600.00	59,888,940.00	2,184,660.00	96.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,808,200.00	21,084,960.00	-2,276,760.00	112.11
210404	Ном, хэвлэл	5,114,000.00	450,000.00	4,664,000.00	8.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,984,200.00	630,000.00	2,354,200.00	21.11
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,108,600.00	29,183,300.00	4,925,300.00	85.56
2105	Нормативт зардал	4,237,900.00		4,237,900.00	
210502	Хоол, хүнс	1,765,800.00		1,765,800.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,472,100.00		2,472,100.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,181,000.00	43,388,270.00	2,792,730.00	93.95
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,850,000.00	19,054,070.00	795,930.00	95.99
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00		100
210604	Урсгал засвар	23,331,000.00	21,334,200.00	1,996,800.00	91.44
2107	Томиллолт, зочны зардал	154,911,200.00	143,643,800.00	11,267,400.00	92.73
210702	Дотоод албан томиллолт	154,911,200.00	143,643,800.00	11,267,400.00	92.73
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,124,900.00	14,458,354.00	7,666,546.00	65.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,330,500.00	7,921,950.00	3,408,550.00	69.92
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	706,300.00		706,300.00	

Архангай аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	2,444,300.00	2,444,300.00		100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	710,200.00	439,304.00	270,896.00	61.86
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	292,900.00	187,000.00	105,900.00	63.84
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,465,800.00	3,465,800.00		100
210807	Газрын төлбөр	3,174,900.00		3,174,900.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,501,380,000.00	1,373,550,569.00	127,829,431.00	91.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,492,500,000.00	1,365,519,939.00	126,980,061.00	91.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,880,000.00	8,030,630.00	849,370.00	90.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	277,819,300.00	255,218,729.00	22,600,571.00	91.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	277,819,300.00	255,218,729.00	22,600,571.00	91.87
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	169,612,300.00	167,656,192.00	1,956,108.00	98.85
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,000,000.00	12,294,000.00	706,000.00	94.57
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	95,207,000.00	75,268,537.00	19,938,463.00	79.06
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,000,000.00	500,000,000.00		100
	Дотоод эх үүсвэрээр	500,000,000.00	500,000,000.00		100
222001	Тоног төхөөрөмж	500,000,000.00	500,000,000.00		100
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,680,140,400.00	5,777,795,430.80	902,344,969.20	86.49
	Орон нутгийн төсвөөс	6,672,140,400.00	5,772,027,400.72	900,112,999.28	86.51
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	8,000,000.00	5,768,000.08	2,231,999.92	72.10
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	77	69	8	90.79
6	Удирдах ажилтан	11	10	1	90.91
7	Гүйцэтгэх ажилтан	48	41	7	91.49
8	Үйлчлэх ажилтан	18	18	0	88.89

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	503,421,605.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	503,421,605.13
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	55,016,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	340,197,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	108,207,355.13
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	503,421,605.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	503,421,605.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	500,410,030.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,073,916.00
210101	Үндсэн цалин	5,925,998.00
210105	Гэрээт ажлын хөлс	51,147,918.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,104,269.53
210201	Тэтгэврийн даатгал	7,104,269.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	
2104	Хангамж, бараа материалын зардал	442,800.00
210402	Тээвэр, шатахуун	442,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	435,789,045.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	410,206,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,582,795.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,011,574.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох	3,011,574.60
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,011,574.60
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	503,421,605.13
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18,513.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 15.2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэснийг зөрчсөн мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мөнгөн гүйлгээний тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 525,667.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 286,758.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, 2,950.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 235,958.8 мянган төгрөгийн хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 9 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь **525,667.2** мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **46,760.9** мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байх тул “**Хязгаарлалттай**” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Байгууллагын даргын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Б/105 дугаар тушаалаар албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо нэр бүхий албан хаагчид 1,000.0 мянган төгрөгийн урамшууллыг илүү тооцож шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.1.2 Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас албан хаагчдын спорт заалны төлбөрт 1,950.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь төсвийг зориулалт бус хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д " Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1 "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.3-т "үр ашигтай байх; 4.1.6-д "сахилга баттай байх", 4.2.6.үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй ...санхүүжилт гаргахгүй байх" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

5.2.1 Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитад хамруулах нь нягтлан бодогчийн хуулиар хүлээсэн үүрэг бөгөөд төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан үндэслэлээр аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны Б/33 дугаар тушаалаар нягтлан бодогчид 1,403.1 мянган төгрөгийн урамшуулал олгож төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

5.2.2 Аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогчийн сул орон тоог холбогдох хуулийн дагуу нөхөж арга хэмжээ аваагүй, түр орлон гүйцэтгэгч томилж 28,726.3 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ", 31.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд дараах тохиолдолд авч ажиллуулахыг хориглоно", 31.1.1-д "энэ хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй", Төрийн албаны зөвлөлийн 2024.12.18-ны өдрийн 548 дугаар тогтоол болон аймгийн ЗДТГ-ын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/27 дугаар тушаалаар баталсан "Албан тушаалын тодорхойлолт"-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

5.2.3 Аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны Б/56 дугаар тушаалаар орон тоонд байхгүй бүсийн хөгжлийн асуудал хариуцсан ажилтныг түр томилж тайлант онд 5,212.8 мянган төгрөгийн цалин хөлс олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл "Хэмнэлтийн бусад арга хэмжээ", 15.1.-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

5.2.4 Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 109/ШШ2024/0023 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 211/МА024/0759 дүгээр магадлал, Улсын Дээд шүүхийн 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 001/ШХТ2025/0074 дүгээр тогтоолоор Ц.Бадрахыг урьд эрхэлж байсан ажилд эгүүлэн тогтоож, ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх олговорт 66,682.6 мянган төгрөгийг аймгийн Засаг даргаас гаргуулж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлж, бичилт хийлгэхийг

даалгасан байна. Гэтэл тус шүүхийн шийдвэрийг үндэслэн дээрх нөхөн олговрыг байгууллагын нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшууллын зардлаас олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т, “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, Төрийн албаны тухай хуулийн 50.1-т Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ” гэж заасны дагуу нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

5.2.5 Тайлант онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс бэлэг дурсгал, гадаад явах зардлын дэмжлэг, онгоцны тийз зэрэгт нийт 184,733.5 мянган төгрөгийг хэмнэлтгүй, зориулалт бус зарцуулсан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1 “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3-т “үр ашигтай байх;”, 4.1.6-д “сахилга баттай байх”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

5.2.6 Байгууллагын өмч хөрөнгөд бүртгэлтэй 235,958.8 мянган төгрөгийн хөрөнгийг эд хариуцагчийн картаар бүртгэлжүүлээгүй, эзэмшигч нь нь тодорхойгүй, жилийн эцсийн тооллогын комисс, өмч хамгаалах байнгын зөвлөлөөс холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх; 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-д “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”- 2.2.2-д “Зөвлөл нь төрийн өмчийг

үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтээх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй”, 3.1-д“... эд хөрөнгийг ашиглаж буй албан хаагч, ажилтанд “эд хөрөнгө хариуцагчийн карт”-аар хариуцуулж бүрэн байдлыг хангуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч хөрөнгийн бүртгэл, хяналт сул байгаа зөрчлийг таслан зогсоож, холбогдох албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг дутуу бүртгэсэн	1	18513.7	1	18513.7								
Нийт дүн	1	18513.7	1	18513.7								

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүтэц орон тоотой холбоотой асуудал	3	33,939.2			3	33,939.2						
Томилгоотой холбоотой	1	66,682.6			1	66,682.6						
Зардлын данстай холбоотой асуудал	3	4,353.1	2	2950.0	1	1403.1						
Нөөц сантай холбоотой	1	184,733.5			1	184,733.5						
Өмч хөрөнгөтэй холбоотой	1	235,958.8							1	235,958.7		
Нийт дүн	9	525,667.2	2	2950.0	5	398,460.3			1	235,958.7		